



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар Б/21

Модот

Б.Адъяахүүг ажилд томилох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, 33.3.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47,48,49 дүгээр зүйл дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан Баатарын Адъяахүүгийн ээлжийн амралтын хугацаа дууссан тул 2024 оны 07 сарын 25-ны өдрөөс эхлэн ажилд эргүүлэн томилж ажиллуулсугай.

2.Б.Адъяахүүгийн хариуцах эд хөрөнгийг эд хөрөнгө ашиглалтын бүртгэлээр хүлээлцэхийг нярав (Г.Золбоо)-д үүрэг болгосугай.

3.Б.Адъяахүүгийн цалинг 07 дугаар сараас тооцож олгохыг нягтлан бодогч (Д.Ганчимэг)-т зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ